



┌ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ┐
ҮЙЛДВЭРИЙН САЙД Ц.ИДЭРБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.06.18 № 37

┌ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт, ┐
тулгамдаж буй асуудлын талаар

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн ажлын байрыг дэмжих, малчид, үйлдвэрлэгчдийн орлогыг өсгөх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд мал эмнэлэг, хорио цээрийн шаардлага хангуулах, экспортын зөвшөөрлийг ил тод болгох, тээвэр логистик, хилийн нэвтрүүлэх хүчин чадал, үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, боловсруулалтын түвшинг сайжруулах болон экспортын орлогын тодорхой хувь хэмжээ малчин, үйлдвэрлэгчдэд бодитоор хүрэхгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, бүтэц, экспортын орлого, гол нэр төрлийн бүтээгдэхүүн, сүүлийн 10 жилд аж ахуйн нэгжид олгосон зөвшөөрлийн сүүлийн 10 жилийн статистик мэдээлэл;

2.Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир, газар тариалангийн бүтээгдэхүүний экспортод голлох байр суурь эзэлж байгаа улсуудын талаарх судалгааны мэдээлэл;

3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортлоход тулгарч буй мал эмнэлэг, хорио цээр, лабораторийн шинжилгээ, олон улсын стандарт, тээвэр логистикийн хүндрэл зэрэг асуудлаар хийсэн судалгаа, үнэлгээний талаарх мэдээлэл;

4.Экспортын зөвшөөрөл, квот олголтод тавигдах шалгуур, хариуцах байгууллага;


5.Малчид, хоршоод, үндэсний үйлдвэрлэгчдийг экспортын сүлжээнд бодитоор оролцуулах, экспортын бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинэ зах зээл нээх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн шинэчлэлт болон санхүүжилт, зээл, дэмжлэгийн үр дүнгийн талаар;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Б.УЯНГА



2026061807